

**ЗУСЛАНГИЙН БҮСИЙГ ХОТЫН ТӨВИЙН БҮСТЭЙ ХОЛБОХ ХӨНГӨН ГАЛТ ТЭРЭГ
(LRT) НЭВТРҮҮЛЭХ ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ЗАГВАР
ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ ГЕОДЕЗИ, БАЙР ЗҮЙН
ЗУРАГЛАЛЫН АЖЛЫН ДААЛГАВАР**

2025 оны 01 сарын 10-ны өдөр

Хавсралт-1

Улаанбаатар хот

**Хавсралт-1 нь АЗТБНТХН УТУГ-ын дугаар даалгаврын хамт хүчин төгөлдөр
байна.**

1	Үндэслэл	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай - Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” - Улаанбаатар хотыг 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепц - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр - Нийслэлийн Засаг даргын 2024 оын А/1370 дугаар захирамж
2	Зорилго	<p>Улаанбаатар хотын нийтийн тээврийн системд хөнгөн галт тэрэг болох (LRT) Трамвайг барьж байгуулах бөгөөд зуслангийн бүсийг хотын төвтэй холбож нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах, авто замын нягтрал, замын ачаалал, хөдөлгөөн зохион байгуулалтыг сайжруулах явдал юм. Тус төслийн зорилго нь нийтийн тээвэрт шинэ соёл, стандарт шаардлага тогтоох, иргэдийн тав тух, аюулгүй байдлыг хангасан үйлчилгээг үзүүлэх, мөн Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөлт, архитектур орон зайн төлөвлөлтийн шийдэл, нийгэм эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулж, авто замын нөхцөл байдлыг судлан тогтоож, хөдөлгөөний ачааллыг бууруулах зорилготой.</p>
3	Байршил, хамрах хүрээ /урьдчилсан/	<p>Бага тойруугийн гудамж, Их сургуулийн гудамж, ногоон нуурын гудамж, Чингэлтэйн өргөн чөлөө, Санзайн замууд хамаарна.</p>
4	Ашиглах материал	<p>Монгол Улсын хуулиуд:</p> <ul style="list-style-type: none"> • “Геодези, зураг зүйн тухай” хууль • “Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай” хууль • Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоол <p>Норм, нормативын баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> • “Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил” /БД 11-104-19/ барилгын дүрэм. “Навигацийн хиймэл дагуул /СМ38/-ын технологиор Монгол Улсын геодезийн сүлжээ байгуулах” барилгын норм ба дүрэм БНБД 11-13-22 • “1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил” /БД 11-106-08/ барилгын дүрэм • Нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөр, агаарын зураглал ба газрын зураг гүйцэтгэх ажил /БД 11-124-21/ барилгын дүрэм • “Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдгийн стандарт MNS 6702:2017” /“Масштаб: 1:500, 1:1 000, 1:2 000, 1:5 000/ • Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил /БД 11-105-19/ барилгын дүрэм

		<ul style="list-style-type: none"> • “Байр зүйн болон дэвсгэр тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн санг хөтлөх” журам • “Хиймэл дагуул (GPS/ГЛОНАСС)-ын технологиор монгол улсын геодезийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм” /БнБД 14-101-08/ барилгын норм ба дүрэм • Өндрийн III ба IV ангийн сүлжээ байгуулах” /БД 11-121-19/ барилгын дүрэм • ГХГЗЗГ-ын даргын 2014 оны А/112 дугаар тушаал /Солбицлын эринг батлах тухай/ • ГХГЗЗГ-ын даргын 2014 оны А/261 дугаар тушаал /Геоидын өндрийн загвар батлах тухай/
5	Боловсруулах хугацаа, тайлангийн бүрдэл	<ul style="list-style-type: none"> • Гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэнэ. • Тайланг 3% үйлдэнэ. Үүнд: Геодези, байр зүйн зураглалын ажлын тайланг 3% хэвлэх, дэвсгэр зургийг ХБХСГ-ын мэдээллийн сангийн баримталж буй хуваалгаар хуваасан байдлаар 1% хэвлэх, Байр зүйн тоон зураг, DSM, DEM, орто зураг холбогдох тоон геомэдээллүүдийг (.gdb, .dwg) форматаар- 3% DVD дээр бичих
6	Гүйцэтгэгч байгууллага	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компани
7	Захиалагч байгууллага	<ul style="list-style-type: none"> • “Нийслэлийн Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” УТҮГ
8	Шаардагдах хөрөнгийн эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> • Улсын төсөв
9	Хянаж баталгаажуулах байгууллага	<ul style="list-style-type: none"> • ГЗБГЗЗЕГазар • Хот байгуулалт, хотын стандартын газар
10	Онцгой нөхцөл	<p>Байр зүйн зураглалын ажлыг холбогдох норм, стандартын дагуу гүйцэтгэх бөгөөд мэргэжлийн байгууллагуудад хүлээлгэн өгч, актаар баталгаажуулна. Үүнээс гадна доорх зүйлсийг заавал биелүүлэхэд анхаарна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Авто замын хэмжилтийг замын хашлага /бордьюр/-ын ёроолоор хэмжинэ. Зураглалын ажлын хилийн хүрээнд хаялбарыг таслахгүй /зөвхөн барилгын хаялбарыг таслана/ • Зураглалын талбайд хамрагдаж байгаа барилга, байгууламжийн булангийн цэгийн өндөр, бичиглэл болон барилгын давхрын тоог /зоорийн давхартай эсэхийг хамт тэмдэглэх/, заавал хэмжиж, тэмдэглэх • Зураглалын нийт талбайд авто зам, төмөр зам, одоо байгаа газар дээрх, газар доорх инженерийн шугам сүлжээний байршил болон өндрийг хэмжсэн цэгүүдийг заавал тусгасан байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Цэвэр усны шугам, худгууд - Ариутгах татуургын шугам, худгууд - Хөрсний усны шугам, худгууд - Зам талбайн борооны усны шугам, худгууд - Дулааны шугам сүлжээ, худгууд - Цахилгаан дамжуулах агаарын шугам, тулгуур - Газар доорх цахилгааны кабель шугам

	<p>- Мэдээлэл холбооны шугам, худгууд</p> <ul style="list-style-type: none"> • Зам дагуу тарьсан модыг нэг бүрчлэн тоо ширхэгээр нь зурагт тусгана • 2 км-с ихгүй зайтай түр цэг суулгаж, геодезийн зураглалын сүлжээ байгуулах • Орто зургийн мэдээллээр хангаж, дэвсгэр зурагтай холболт хийх • Захиалагч талаас ажлын явцад нэмэлтээр хэмжилт зураглал хийх шаардлагатай гэж үзвэл харилцан тохиролцсоны үндсэн дээр хэрэгцээ шаардлагад нийцсэн зураглал хийх • Бусад. Захиалагч талаас ирүүлсэн үндсэн даалгавар
--	--

ХЯНАСАН:


ХОТ ТӨЛӨВЛӨЛТ СУДАЛГААНЫ ИНСТИТУТИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР:



О.ОДБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ СУДАЛГААНЫ ИНСТИТУТИЙН
ЗАМ, ТЭЭВЭР СУДАЛГАА ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН :



Д.ДАВААЖАРГАЛ